



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/412

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын үйлдвэрлэл эрхлэгчдэд мал төхөөрөх цехийн үйл ажиллагаа болон техник, технологи, туршлага судлуулах ажлыг зохион байгуулахад шаардагдах шатахуун, байрны зардалд 1,900,000 (нэг сая есөн зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 1,900,000 (нэг сая есөн зуун мянга) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100874